



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/100/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот  
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn  
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг  
Утас: 261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn  
Гэрээгээр гүйцэтгэсэн: Шинэ баланс аудит ХХК  
Захирал: Б.Мэндбаяр  
Утас: 70109154  
Цахим хаяг: mendbayar@shinebalans-audit.mn

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	11
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	13
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
8. Аудитын илрүүлэлт .....	14
8.1 Албан шаардлага .....	14
8.2 Зөвлөмж .....	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДЭХ	Дулааны эрчим хүч
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭХХТ	Эрчим хүчний хөгжлийн төв



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Н.ГАНБААТАР ТАНАА

2022.03.15 № 07/520  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон зүйл

Багануурын дулааны станц ТӨХК-ийн үндсэн түүхий эд болох нүүрсний үнэ тайлант онд 3 дахин нэмэгдсэн, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гэрээний маргаанаас шалтгаалан 2 зуух ашиглалтгүй болсон, эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн 7,574.5 сая төгрөгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр төрийн өмчид, 1,021.7 сая төгрөгийг дахин үнэлгээний нэмэгдэл дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитынхаа хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзэн, тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/186 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн зорилтот түвшний орлогыг 6,792.7 сая төгрөгөөр, зардлыг 8,301.3 сая төгрөгөөр, алдагдлыг 1,508.5 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 6,813.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 8,354.0 сая төгрөгийн зардал гарган, 1,540.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

## Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус компани нь тайлант онд дүүргийн хэрэглэгчдийг Дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангахын тулд тоноглолуудын найдвартай ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэлийг хангах үүднээс 22 ажлыг төлөвлөн 100 хувь гүйцэтгэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,123,829.66	6,995,683.20
1.1.02	Дансны авлага	572,641,549.43	105,230,335.34
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.04	Бусад авлага	216,874,397.52	301,583,129.30
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.06	Бараа материал	219,718,973.31	150,810,494.46
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	44,200,000.00	-
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,058,558,749.92</b>	<b>564,619,642.30</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.01	Үндсэн хөрөнгө	9,636,001,529.92	8,739,442,236.40
1.2.02	Биет бус хөрөнгө	1,021,721,600.00	1,021,721,600.00
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	37,624,462.56	88,089,559.66
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>10,695,347,592.48</b>	<b>9,849,253,396.06</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,753,906,342.40</b>	<b>10,413,873,038.36</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.01	Дансны өглөг	368,832,722.09	749,325,021.95
2.1.1.02	Цалингийн өглөг	0.01	-
2.1.1.03	Татварын өр	1,182,684,293.13	1,011,315,233.96
2.1.1.04	НДШ - ийн өглөг	240,828,205.93	53,442,846.41
2.1.1.05	Богино хугацаат зээл	400,000,000.00	400,000,000.00
2.1.1.06	Хүүний өглөг	-	-
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	17,010,895.71	28,176,027.74
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	44,719,267.15	1,324,600.20
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12	Хойшлогдсон орлого	-	165,548,271.71
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,254,075,384.02</b>	<b>2,409,132,001.97</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	17,350,850.65	17,350,850.65
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>17,350,850.65</b>	<b>17,350,850.65</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,271,426,234.67</b>	<b>2,426,482,852.62</b>
2.3	Эздийн өмч		
2.3.01	Өмч: - төрийн	6,291,517,841.35	13,866,061,041.27
2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,652,391,027.32	3,674,112,627.32
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	8,884,371,757.16	283,181,595.04
<b>2.3.09</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>(8,345,800,518.10)</b>	<b>(9,835,965,077.89)</b>
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	(677,348,518.34)	(1,490,164,559.79)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(7,668,451,999.76)	(8,345,800,518.10)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>9,482,480,107.73</b>	<b>7,987,390,185.74</b>

2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,753,906,342.40</b>	<b>10,413,873,038.36</b>
-----	---------------------------------------	--------------------------	--------------------------

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>5,562,221,622.44</b>	<b>5,650,487,899.24</b>
2	Борлуулалтын өртөг	6,708,426,104.74	7,694,895,378.27
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>(1,146,204,482.30)</b>	<b>(2,044,407,479.03)</b>
4	Түрээсийн орлого	3,624,400.00	3,182,400.00
5	Хүүний орлого	251,294.16	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	1,055,165,204.60	1,061,366,530.24
<b>8.1</b>	<b>Орлогын дүн</b>	<b>1,059,040,898.76</b>	<b>1,064,548,930.24</b>
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	352,039,765.81	356,780,216.47
11	Санхүүгийн зардал	61,149,200.29	31,919,208.55
12	Бусад зардал	-	-
<b>12.1</b>	<b>Зардлын дүн</b>	<b>413,188,966.10</b>	<b>388,699,425.02</b>
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	(195,529,337.60)	(172,071,683.08)
<b>17.1</b>	<b>Олз, гарзын дүн</b>	<b>(195,529,337.60)</b>	<b>(172,071,683.08)</b>
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>(695,881,887.24)</b>	<b>(1,540,629,656.89)</b>
19	Орлогын татварын зардал	18,533,368.90	50,465,097.10
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(677,348,518.34)</b>	<b>(1,490,164,559.79)</b>
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(677,348,518.34)</b>	<b>(1,490,164,559.79)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>6,291,517,841.35</b>	<b>2,652,391,027.32</b>	<b>8,601,190,162.12</b>	<b>(7,668,451,999.76)</b>	<b>9,876,647,031.03</b>
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	<b>6,291,517,841.35</b>	<b>2,652,391,027.32</b>	<b>8,601,190,162.12</b>	<b>(7,668,451,999.76)</b>	<b>9,876,647,031.03</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(677,348,518.34)	(677,348,518.34)
<b>2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>6,291,517,841.35</b>	<b>2,652,391,027.32</b>	<b>8,884,371,757.16</b>	<b>(8,345,800,518.10)</b>	<b>9,482,480,107.73</b>
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	<b>6,291,517,841.35</b>	<b>2,652,391,027.32</b>	<b>8,884,371,757.16</b>	<b>(8,345,800,518.10)</b>	<b>9,482,480,107.73</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,490,164,559.79)	(1,490,164,559.79)

Өмчид гарсан өөрчлөлт	7,574,543,199.92	-	8,601,190,162.12)	-	(1,026,646,962.20)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	1,021,721,600.00	-	-	1,021,721,600.00
<b>2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>13,866,061,041.27</b>	<b>3,674,112,627.32</b>	<b>283,181,595.04</b>	<b>(9,835,965,077.89)</b>	<b>7,987,390,185.74</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>5,014,096,546.08</b>	<b>5,836,005,777.84</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,835,582,905.76	4,454,375,334.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,978,174.00	43,664,973.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,010,000,000.00	1,081,900,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	160,535,466.32	256,065,470.84
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,962,102,070.95</b>	<b>5,286,326,001.24</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,932,915,518.89	2,051,320,426.17
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	646,378,698.95	864,395,342.82
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	454,895,650.35	242,851,050.97
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	327,221,075.38	623,738,489.07
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	333,001,374.50	342,117,789.74
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	47,030,045.83	27,060,657.54
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	298,590,997.70	834,097,512.03
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	6,511,180.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	915,557,529.35	300,744,732.90
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>51,994,475.13</b>	<b>549,679,776.60</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>251,294.16</b>	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	251,294.16	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>225,211,776.00</b>	<b>547,807,923.06</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	225,211,776.00	547,807,923.06
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(224,960,481.84)</b>	<b>(547,807,923.06)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>400,000,000.00</b>	<b>400,000,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	400,000,000.00	400,000,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-



3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>226,831,678.17</b>	<b>400,000,000.00</b>
3.2.1	Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	226,831,678.17	400,000,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>173,168,321.83</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>202,315.12</b>	<b>1,871,853.54</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,921,514.54</b>	<b>5,123,829.66</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,123,829.66</b>	<b>6,995,683.20</b>

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь	
1	Боловсруулсан	ЦЭХ	сая.кВтц					
		ДЭХ	мян.Гкал	164.4	158.8	164.1	5.3	3.3
	Дотоод хэрэгцээний дулаан эрчим хүчний зарцуулалт	хувиар	хувь	2.9	2.9	2.3	(0.6)	(21.7)
		биетээр	сая.кВт.ц	4.8	4.6	3.7	(0.9)	(19.2)
	Эрчим хүч түгээлт	ЦЭХ	сая.кВтц	-	-	-	-	-
ДЭХ		мян.Гкал	159.6	154.2	160.4	6.2	4.0	
2	<b>Нийт орлого</b>		<b>сая.төг</b>	<b>6,713.1</b>	<b>6,792.8</b>	<b>6,813.4</b>	<b>20.6</b>	<b>0.3</b>
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	5,562.2	5,633.5	5,650.5	17.0	0.3
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	140.9	77.4	81.0	3.6	4.7
		Санхүүжилт (татаас)	сая.төг	1,010.0	1,081.9	1,081.9	-	-
3	<b>Нийт зардал</b>		<b>сая.төг</b>	<b>7,409.0</b>	<b>8,301.3</b>	<b>8,354.0</b>	<b>52.7</b>	<b>0.6</b>
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	7,121.6	8,167.4	8,083.6	(83.8)	(1.0)
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	287.4	133.9	270.4	136.5	102.0
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	сая.төг	719.4	1,444.7	1,446.2	1.5	0.1	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	(695.9)	(1,508.5)	(1,540.6)	(32.1)	2.1
5	<b>Татварын дараах ашиг/алдагдал</b>		<b>сая.төг</b>	<b>(677.4)</b>	<b>(1,508.5)</b>	<b>(1,490.2)</b>	<b>18.3</b>	<b>(1.2)</b>
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.3	1.4	1.4	-	(1.3)
7	<b>Нийт авлага</b>		<b>сая.төг</b>	<b>789.5</b>	<b>175.0</b>	<b>406.8</b>	<b>231.8</b>	<b>132.4</b>
	Үүнээс:	ЭХ-ний	сая.төг	778.7	165.0	257.0	92.0	55.8
		Бусад	сая.төг	10.8	10.0	149.8	139.8	1,398.0
8	<b>Нийт өглөг</b>		<b>сая.төг</b>	<b>2,254.1</b>	<b>1,700.0</b>	<b>2,409.1</b>	<b>709.1</b>	<b>41.7</b>
	Үүнээс	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	2,254.1	1,700.0	2,409.1	709.1	41.7
9	Нийт ажиллагсдын тоо		тоо	141	141	141	-	-
10	Нийт цалингийн сан		сая.төг	2,299.6	2,313.2	2,335.0	21.8	0.9
11	Нэг сарын дундаж цалин	Нийт ажиллагсдын	сая.төг	1,359.1	2,313.2	1,323.3	(989.9)	(42.8)
		Удирдлагын	сая.төг	2,736.7	1,367.1	2,924.3	1,557.2	113.9
		ИТА-ын	сая.төг	1,855.3	2,824.1	2,018.5	(805.6)	(28.5)
		Ажилчдын	сая.төг	1,123.3	1,797.9	1,171.0	(626.9)	(34.9)
12	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	цахилгаан	гр/кВтц	179.9	187.1	187.5	0.4	0.2
13	<b>Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт</b>		<b>сая.төг</b>	<b>480.4</b>	<b>414.1</b>	<b>397.1</b>	<b>(17.0)</b>	<b>(4.1)</b>
	Үүнээс:	Их засварт	сая.төг	198.3	99.1	96.2	(2.9)	(2.9)
		ТЗБАХ-нд	сая.төг	138.2	17.0	17.0	-	-
		Хөрөнгө оруулалтанд	сая.төг	143.9	298.0	283.9	(14.1)	(4.7)

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад худалдан авалт хийхдээ НӨАТ төлөгч бэлтгэн нийлүүлэгчийг сонгож байх, зарлагын гүйлгээнд и-баримтыг бүрдүүлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 14-нөөс 2022 оны 03 дугаар сарын 09-ний хооронд Шинэ баланс аудит ХХК-ийн аудитор Г.Гантуяа, аудиторын туслах Ц.Болортуяа, Ш.Жавзанпагма, С.Цэрэндаш нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Б.Мэндбаяр хэрэгжүүлсэн.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1/37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Компанийн дотоод аудитор нь жилийн ажлын төлөвлөгөөг удирдлагаар батлуулан, төлөвлөгөөний дагуу шилэн дансны хуулийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаа, захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа зэрэгт дотоод хяналтыг хийж, шалгалтын үр дүн, зөвлөмжийг холбогдох албаны дарга нарт хүргүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлын тайлантай танилцаж, худалдан авах ажиллагаатай холбоотой материалыг аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох суурь үзүүлэлтийг орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт

зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөх үе шатанд материаллаг байдлыг тооцохдоо 2020 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон ба 2021 оны санхүүгийн тайлангаарх орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 8,083.6 сая төгрөг болж өссөн тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1.5 хувиар 121.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

#### **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

##### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Багануурын дулааны станц ТӨХК-ийн зорилго нь хэрэглэгчийг эрхэмлэн дээдэлж, дэвшилтэт технологид тулгуурласан дулааны эрчим хүчээр найдвартай хангаж, эдийн засгийн үр ашигтай ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах, дулаан түгээх, дулаан үйлдвэрлэх” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 39.0 хувь, Эрчим хүчний яам 41.0 хувь, Сангийн яам 20.0 хувийг эзэмшиж байна.

##### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

“Багануурын дулааны станц” ТӨХК нь 1980 онд 25 тн ханасан уур үйлдвэрлэх хүчин чадалтайгаар, Багануурын нүүрсний уурхайг дулааны эрчим хүчээр хангах зорилготойгоор байгуулагдсан байна. Компани нь 1983 онд усан халаалтын 6 зуухыг, 1989 онд 2 зуух, уур үйлдвэрлэх 1 зуухыг нэмж ашиглалтад оруулснаар жилд 300 мян.Гкал дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай болж өргөжсөн байна.

Тус компани 2003 оны Төрийн өмчийн хороо /хуучнаар/-ны 224 дүгээр тогтоолоор хувьчлагдаж, 2006 оны 529 дүгээр тогтоолоор “Багануур” ХК-ийн охин компани болсон байна. Хуулийн этгээдийн өмчлөлийн хэлбэр хэд хэдэн удаа өөрчлөгдсөн ба 2008 онд Төрийн өмчийн хорооны 88 дугаар тогтоолоор тус компанийг бие даасан Төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 13 дугаар тогтоолоор, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 01, 02 дугаар тогтоолоор томилсон нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” гэсэн заалттай нийцэж байна.

Багануурын дулааны станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 65.4 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг тогтоох тухай саналаа ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт /тариф/-ын 3 талт хэлэлцээр.

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,123.8	6,995.7	1,871.9
Авлага	833,715.9	406,813.5	(426,902.5)
Бараа материал	219,719.0	150,810.5	(68,908.5)
Үндсэн хөрөнгө	9,636,001.5	8,739,442.2	(896,559.3)
Биет бус хөрөнгө	1,021,721.6	1,021,721.6	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	37,624.5	88,089.6	50,465.1
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>11,753,906.3</b>	<b>10,413,873.0</b>	<b>(1,340,033.3)</b>
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>2,271,426.2</b>	<b>2,426,482.9</b>	<b>155,056.6</b>
Богино хугацаат өглөг	2,254,075.4	2,409,132.0	155,056.6
Урт хугацаат өглөг	17,350.9	17,350.9	-
Эздийн өмч	9,482,480.1	7,987,390.2	(1,495,089.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>11,753,906.3</b>	<b>10,413,873.0</b>	<b>(1,340,033.3)</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.4 сая төгрөгийн касс дах бэлэн мөнгө, 6.5 сая төгрөгийн арилжааны харилцах дансанд байршиж байгаа мөнгөн хөрөнгө байна.

Тайлант онд авлага 426.9 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 211 дугаар тогтоолоор баталсан “Дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр”-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэлх 13 сарын хугацаанд айл өрх, албан байгууллагын хэрэглэсэн дулааны эрчим хүчний төлбөрийг хариуцсантай холбоотой айл өрхийн ДЭХ-ний төлбөрийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар бүрэн төлөгдсөн, айл өрхөөс авах авлага барагдсанаас шалтгаалжээ.

Найдваргүй авлагыг нөөцийн буюу хасагдуулгын аргаар тооцдог байна. Тайлант онд компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/05 дугаар тушаалаар Демситрейд ХХК-аас авах авлага 17.8 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, найдваргүй авлагын хасагдуулгаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 150.8 сая төгрөг болж 68.9 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны жилийн эцэст бичиг хэрэг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн худалдан авалтыг хийснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө нь худалдан авсан 401.3 сая, их засварын капиталжуулсан 59.0 сая, ТӨБЗГ-ын 2021 оны 556 дугаар тогтоолоор тоног төхөөрөмжийн ашиглах хугацааг сунгаж, дахин үнэлсэн 165.5 сая, Багануур Дүүргийн Засаг Даргын Тамгын Газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 35.0 сая төгрөгийн автомашины дүнгээр нэмэгдсэн байна. ТӨБЗГ-ын 2021 оны 586, А-1/1904, 184 тогтоолоор нийт 136.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь Багануур ХК-аас авч буй нүүрсний үнэ 2021 онд 3 дахин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг эдийн засгийн үр ашгийн бууралт нь хөрөнгийг багасган, өр төлбөрийг нэмэгдүүлж байгаа бөгөөд хэмжиж болохуйц байвал зардлыг хүлээн зөвшөөрч, төлсөн, эсвэл төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжинэ гэж заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий удирдлагын зардал, санхүүгийн зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Зардлыг өмнөх онтой харьцуулахад 961.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нүүрсний үнэ 3 дахин нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цалин, нийгмийн даатгал, урамшуулал, нүүрс, нүүрсний тээврийн зардал, цахилгаан, цэвэр, бохир ус, харуул хамгаалалт, химийн бодис, үндсэн хөрөнгийн элэгдэл, хөдөлмөр хамгаалал, урсгал засвар, шатах тослох материал, татвар, төлбөр хураамж, шугамын түрээс, ариутгал цэвэрлэгээ, сэлбэг хэрэгсэл, сургалт, хангамж, бичиг хэрэг, харилцаа холбоо зэрэг зардлуудыг шингээсэн байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Багануурын дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/24 дүгээр тушаалаар Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 6,716.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 7,080.3 сая төгрөгөөр, 364.2 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 414.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/186 дугаар тушаалаар 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогыг 6,792.7 сая төгрөгөөр, зардлыг 8,301.3 сая төгрөгөөр, алдагдлыг 1,508.5 сая төгрөгөөр тус тус тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 6,813.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 8,354.0 сая төгрөгийн зардал гарган, 1,540.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант онд цэвэр алдагдал 1,540.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 32.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нүүрс, цалин, элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 6,813.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 20.6 сая төгрөг буюу 0.3 хувиар давсан нь үйлдвэрлэлт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 8,354.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 52.7 сая төгрөг буюу 0.6 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь үйлдвэрлэлт нэмэгдсэн, нийт илүү зарцуулалтын 76.2 хувийг нүүрсний зардал эзэлж, гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 39 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээр 397.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Цаашид компанийн алдагдлыг бууруулахын тулд дулааны эрчим хүчний үнэ тарифыг нэмэх, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тогтоож, дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд олгож буй татаас санхүүжилтийг үйлдвэрлэлийн хүчин чадалд үндэслэн ялгаатай тогтоох, дулаан үйлдвэрлэж алдагдал хүлээж буй байдлыг өөрчилж, цахилгаан гаргаад дулаан үйлдвэрлэх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар алдагдлыг бууруулахад анхаарах шаардлагатай байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Багануурын дулааны станц ТӨХК нь тайлант онд нийт 78,799.2 сая төгрөгийн 172 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 37.2 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь : Өмнөх аудитаар шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтан гарсан тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Компанийн үнэлгээний хорооны боловсруулсан харьцуулалтын тендерийн баримт бичиг нь Сангийн яамнаас гаргасан жишиг баримт бичгийн шаардлага хангахгүй, тендерт оролцогчдын өгөгдлийн хүснэгтийн үзүүлэлтүүд өөр байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн материалыг Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн дагуу боловсруулж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 15 дугаар зүйлийн 15.3.2, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудыг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөв.

Тус компанийн цахилгаан тэжээлийн системийн хүчин чадлын өргөтгөл, шинэчлэлт, цахилгаан хөдөлгүүрүүдийн инвертер шинэчлэн суурилуулах угсралтын ажлын ЭХА-002/2018 дугаар бүхий гэрээг 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв болон Зүмбэр Орд өргөө ХХК-ийн хооронд байгуулсан байна. Гэрээнд уг ажлыг 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдөр хүртэл гүйцэтгэж, ашиглалтад оруулахаар заасан боловч улсын комисс хүлээн аваагүй, компанид хүлээлгэн өгөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан эдийн засгийн үзүүлэлт, зорилт түвшнийг үзүүлэлт бүрээр биелүүлэх, өртөг, зардлыг бууруулж ажиллах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, худалдан авах үйл ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТ хууль, төрийн өмчийн бүртгэл, ашиглалтад тавих хяналт нь

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 9,411.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 332.5 сая төгрөгийг залруулж, 9,005.1 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 73.8 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 137.3 сая төгрөгийн зөрчилд 22.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 114.6 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгснөөс албан шаардлага 50.0 хувь, зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт*

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	22,700.0	1	22,700.0	1	-	50.0
Зөвлөмж	8	114,600.0	8	114,600.0	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>137,300.0</b>	<b>9</b>	<b>137,300.0</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>50.0</b>

Өмнөх аудитаар шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтан гарсан тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нүүрс худалдан авалт, тээвэрлэлтийн биет хэмжээг шалгах, нүүрс тээвэрлэлтийн 1тн/км-ын үнэлгээг Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар баталсан жишиг үнийг үндэслэн тогтоосон эсэх, хөрөнгө оруулалтын гэрээнээс шалтгаалан ашиглалтгүй болсон К-4, К-9 зуухыг хэвийн горимд шилжүүлэх маргаантай асуудал шийдвэрлэгдсэн эсэх, их засвар болон хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэлийн биет байдлыг шалгах, төлбөрт үйлчилгээний орлого, Төв магистрал Ф700х12 мм, Ф500х10 мм-ийн шугам сүлжээг зохих ачаалалд тохируулан шинэчлэх ажлын хөрөнгийг шийдвэрлэж, ажил хийгдсэн зэргийг шалгана.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 106.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 32.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 74.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 106.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 121.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### 8.1 Албан шаардлага

Газар эзэмших гэрчилгээтэй Багануур дүүргийн 1 дүгээр хороонд байрлалтай 140 м2, 3 дугаар хороонд байрлах 1000 м2 газрыг үнэлээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын 4 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газрын эзэмших эрхийг үнэлэн санхүүгийн тайланд тусгах арга хэмжээ зохион байгуулах талаар албан шаардлага өгөв.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/186 дугаар тушаалаар 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогыг 6,792.7 сая төгрөгөөр, зардлыг 8,301.3 сая төгрөгөөр, алдагдлыг 1,508.5 сая төгрөгөөр тодотгож баталсан байна. Гүйцэтгэлээр 6,813.4 сая төгрөгийн

орлого бүрдүүлж, 8,354.0 сая төгрөгийн зардал гарган, 1,540.6 сая төгрөгийн алдагдалтай буюу төлөвлөснөөс алдагдлыг 32.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг үзүүлэлт бүрээр биелүүлэх, өртөг, зардлыг бууруулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

## **8.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Татвартай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Компани нь Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бус 4 бэлтгэн нийлүүлэгчээс 73.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь НӨАТ-ын буцаан авалтаа эдлэх боломжгүй болгож, зардал өсөхөд хүргэсэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 "Монгол Улсын нэтэг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх албан татвараас хасаж тооцно" гэсэн заалтыг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтыг хийхдээ НӨАТ төлөгч хуулийн этгээдийг сонгож, компанийн НӨАТ-ын буцаалтыг нэмэгдүүлэх.

### **2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа 0.4 сая төгрөгийн гүйлгээний и-баримтыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 "Бараа, ажил үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 "Бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан өдөр баримтыг авах" гэсэн заалтыг зөрчиж, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлэх, татварын и-баримтын цахим хуудсанд худалдан авалтын баримтад хяналт хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Аудитын к од	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Багануурын дулааны станц ТӨХК	АХГ-2022/100/НА-СТА-ТӨА	Компани нь Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бус 4 бэлтгэн нийлүүлэгчээс 73,888.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь НӨАТ-ын буцаан авалтаа эдлэх боломжгүй болгож, зардал өсөхөд хүргэсэн байна.	Тендер сонгон шалгаруулалтаар хийгддэг худалдан авалт нь 70 сая төгрөгөөс дээш тул тендерийн баримт бичгийн өгөгдлийн нөхцөлд заавал НӨАТ татвар төлөгч хуулийн этгээд байх талаар оруулах.	1	73,888.5									1	73,888.5
2	Багануурын дулааны станц ТӨХК	АХГ-2022/100/НА-СТА-ТӨА	Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа 427.5 мянган төгрөгийн гүйлгээний и-баримтыг бүрдүүлээгүй байна.	Анхан шатны баримтын бүрдлийг анхаарч ажиллах.	1	427.5									1	427.5
3	Багануурын дулааны станц ТӨХК	АХГ-2022/100/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэлээр 6,813.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 8,354.0 сая төгрөгийн зардал гарган, 1,540.6 сая төгрөгийн алдагдалтай буюу төлөвлөснөөс алдагдлыг 32.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан байна.	Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшнийг бүрээр өртөг, зардлыг бууруулж ажиллах	1	32,100.0					1	32,100.0				
4	Багануурын дулааны станц ТӨХК	АХГ-2022/100/НА-СТА-ТӨА	Газар эзэмших гэрчилгээтэй Багануур дүүргийн 1 дүгээр хороонд байрлалтай 140 м2, 3 дугаар хороонд байрлах 1000 м2 газрыг үнэлээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.	Сангийн яамнаас баталсан аргачлалын дагуу газрыг үнэлж, ТӨБЗГ-т хүсэлт тавьж, санхүүгийн тайланд тусгах	1	-					1	-				
ДҮН					<b>4</b>	<b>106,416.0</b>					<b>2</b>	<b>32,100.0</b>			<b>2</b>	<b>74,316.0</b>

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал													
1	Багануурын дулааны станц ТӨХК	АХГ-2022/100/НА-СТА-ТӨА	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.	1	37,215.0					1	37,215.0	
2	Багануурын дулааны станц ТӨХК	АХГ-2022/100/НА-СТА-ТӨА	Компанийн үнэлгээний хорооны боловсруулсан харьцуулалтын тендерийн баримт бичиг нь хууль болон Сангийн яамнаас гаргасан жишиг баримт бичгийн шаардлага хангахгүй, тендэрт оролцогчдын өгөгдлийн хүснэгтийн үзүүлэлтүүд өөр байна.	Тендерийн материалыг Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн дагуу боловсруулах	1	-					1	-	
3	Багануурын дулааны станц ТӨХК	АХГ-2022/100/НА-СТА-ТӨА	Тус компанийн цахилгаан тэжээлийн системийн хүчин чадлын өргөтгөл, шинэчлэлт, цахилгаан хөдөлгүүрүүдийн инвертер шинэчлэн суурилуулах угсралтын ажлын ЭХА-002/2018 дугаар бүхий гэрээг 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв болон Зүмбэр Орд өргөө ХХК-ийн хооронд байгуулсан байна. Гэрээнд уг ажлыг 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдөр хүртэл гүйцэтгэж, ашиглалтад оруулахаар заасан боловч одоог хүртэл улсын комисс хүлээн авч, акт үйлдээгүй, компанид хүлээлгэн өгөөгүй байна.	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, ашиглалтад тавих хяналтыг сайжруулах	1	-					1	-	
			<b>ДҮН</b>		<b>3</b>	<b>37,215.0</b>					<b>3</b>	<b>37,215.0</b>	
			<b>НИЙТ ДҮН</b>		<b>7</b>	<b>143,631.0</b>					<b>5</b>	<b>69,315.0</b>	<b>2</b> <b>74,316.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 342/АД/15/2022

Улаанбаатар хот

АХГ-2022/100/НА-СТА-ТБА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн үнэлгээний хорооны боловсруулсан харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн баримт бичиг нь холбогдох хууль болон Сангийн яамнаас гаргасан тендерийн жишиг баримт бичгийг мөрдөөгүй, тендерт оролцогчдын өгөгдлийн хүснэгтийн үзүүлэлтүүд өөр байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Энэ хуулийн 14.3-т заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх шаардлагатай баримт бичгийг тендерийн баримт бичигт тусгайлан заана", 15 дугаар зүйлийн 15.3.2 "Тендерт оролцогчийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ", 19 дүгээр зүйлийн 19.1 "Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан "Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг"-ийн дагуу боловсруулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануурын дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Ганбаатар, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ц.Энхцэцэг нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"ШИНЭ БАЛАНС АУДИТ" ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ

Б.МЭНДБАЯР

9696189  
9019120398

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-8.Docx

0010800961



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 343/АДТБ.2022  
АХГ-2022/100/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эзэмших эрхийн гэрчилгээтэй Багануур дүүргийн 1 дүгээр хороонд байрлалтай 140 м2, 3 дугаар хороонд байрлах 1000 м2 газрын эзэмших эрхийг үнэлээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ... 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;...", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; ...", мөн Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын 4-д "Үнэлгээнд хамрагдаагүй газар эзэмших, ашиглах эрх, дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу үнэлж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Багануур дүүргийн 1, 3 дугаар хороонд байрлах газрын эзэмших эрхийг үнэлэн, санхүүгийн тайланд тусгах арга хэмжээ зохион байгуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануурын дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Ганбаатар, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ц.Энхцэцэг нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Б.МЭНДБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-10.Docx

0010800965



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 344/АД-15-0055

Улаанбаатар хот

АХГ-2022/100/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний сайдын 2021 оны А/186 дугаар тушаалаар 2021 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогыг 6,792.7 сая төгрөгөөр, зардлыг 8,301.3 сая төгрөгөөр, алдагдлыг 1,508.5 сая төгрөгөөр тодотгож баталсан. Гүйцэтгэлээр 6,813.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 8,354.0 сая төгрөгийн зардал гарган, 1,540.6 сая төгрөгийн алдагдалтай буюу төлөвлөснөөс алдагдлыг 2.1 хувь буюу 32.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг биелүүлж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багануурын дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Ганбаатар, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ц.Энхцэцэг нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ

Б.МЭНДБАЯР

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-9.Docx

0010800963



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 345/АД/150053  
АХТ-2022/100/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Багануурын дулааны станц ТӨХК нь тайлант онд нийт 78,799,180.40 төгрөгийн ажил, гүйлгээний 172 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 37,215,000.00 төгрөгийн ажил, гүйлгээний 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Өмнөх оны аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануурын дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Ганбаатар, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ц.Энхцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Б.МЭНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 дугаар сарын 15

№ 346/АД 1500055

Улаанбаатар хот

АХТ-2022/100/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компанийн цахилгаан тэжээлийн системийн хүчин чадлын өргөтгөл, шинэчлэлт, цахилгаан хөдөлгүүрүүдийн инвертер шинэчлэн суурилуулах угсралтын ажлын ЭХА-002/2018 дугаар бүхий гэрээг 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв болон Зүмбэр Орд өргөө ХХК-ийн хооронд байгуулсан байна. Гэрээнд уг ажлыг 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдөр хүртэл гүйцэтгэж, ашиглалтад оруулахаар заасан боловч одоог хүртэл улсын комисс хүлээн авч, акт үйлдээгүй, ашиглагч компанид хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй: ... 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх хөрөнгийг ашиглагч талд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх, гэрээг дүгнэж акт үйлдэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Захиалагч болон Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, гэрээний талуудын маргааныг эцэслэн шийдвэрлэх арга хэмжээ авч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Жанарбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ШИНЭ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Б.МЭНДБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-764230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardiaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-11.Docx

0010800967





